

ТАНИЛЦУУЛГА

*Хувь хүний орлогын албан татварын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн талаар*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Хүн амын худалдан авах чадварт нийцсэн, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулна” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт эдийн засгийн өсөлтийг дунджаар 6 хувьд хадгалж, нэг хүнд ногдох үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний оролцооны түвшнийг 65 хувьд хүргэнэ гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Үндэсний баялгийн сан, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулалтыг эрчимжүүлэх”, “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр тус тус заасан. Үүний хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй орон сууц барих, засварлахад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, хариуцлагатай татвар төлөгчдийг дэмжих, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, бүс, орон нутагт ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг тусгасан.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, иргэдийн бодит орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцжуулалтыг сайжруулах шаардлага тулгарч буйг харгалзан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах үндсэн чиглэлийг баримталж, холбогдох зохицуулалтыг тусгана. Үүнд:

- Иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах, бусад холбогдох татварын зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно.
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцжуулалтыг татварын бодлогоор дэмжинэ.
- Татвар төлөгчийн татвар төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулж, үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилсан сэргийлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар, иргэн, өрхийн татварын ачаалал буурч, тэдний бодит орлого өсөх, худалдан авах чадвар нэмэгдэх, өрхийн амьжиргаа дээшлэх, бүс орон нутаг бие даасан, өрсөлдөхүйц, ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх, татвар төлөгчдийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой зардал буурах зэрэг эерэг үр дагавартай байна.